

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/140/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
Залруулсан алдаа.....	20
5.2 Албан шаардлага	21
АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/79
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газар нь Си Ти Эс ХХК-ий STSystem 6.0.1 нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг шинээр худалдан авсан бөгөөд 2023 оны санхүүгийн үйл ажиллагааг тус программаар бүртгэн санхүүгийн тайлангаа гаргасан байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 53,135.1 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, орон нутгийн хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээр 247,657.5 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд тусган тайлагнасан байна

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	32,354,258.1	50,224,908.1
33	АВЛАГА	0.0	620,000.0
335	Бусад авлага	0.0	620,000.0
3352	Хувь хүмүүсээс авах авлага	0.0	620,000.0
35	БАРАА МАТЕРИАЛ	31,529,258.1	38,404,908.1
351	Түүхий эд материал	4,769,868.1	19,766,068.1
35110	Тусгай зориулалттай материал	4,769,868.1	19,766,068.1
354	Хангамжийн материал	21,759,390.0	13,638,840.0
35410	Бичиг хэргийн материал	697,400.0	377,400.0
35420	Аж ахуйн материал	10,671,990.0	11,715,190.0
35430	Сэлбэг хэрэгсэл	120,000.0	620,000.0
35450	Барилгын засварын материал	0.0	576,250.0
35470	Бусад хангамжийн материал	10,270,000.0	350,000.0
35600	Мал амьтад	5,000,000.0	5,000,000.0
36	НӨӨЦИЙН БАРАА	825,000.0	11,200,000.0
36600	Бусад нөөц	825,000.0	11,200,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,644,202,577.6	1,794,285,410.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,644,202,577.6	1,794,285,410.9
392	Биет хөрөнгө	1,602,890,397.6	1,751,352,760.9
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,336,541,879.8	1,400,535,079.8
39202	Хуримтлагдсан элэгдэл	-299,925,666.4	-364,008,254.6
39203	Авто-тээврийн хэрэгсэл	216,959,090.0	216,959,090.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-38,801,000.0	-65,441,909.0
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	234,348,659.0	249,274,359.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-65,412,369.6	-90,896,939.8
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	143,896,610.8	165,138,610.8
39208	Хуримтлагдсан элэгдэл	-39,229,991.0	-58,107,642.5
39209	Зам, гүүрийн байгууламж	145,535,664.0	145,535,664.0
39210	Хуримтлагдсан элэгдэл	-31,695,979.1	-40,148,240.1
39214	Бусад үндсэн хөрөнгө	31,400,000.0	230,281,712.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-31,400,000.0	-38,442,268.6
39217	Ном	673,500.0	673,500.0
393	Биет бус хөрөнгө	41,312,180.0	42,932,650.0
39301	Програм хангамж	420,300.0	2,170,300.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-168,120.0	-297,650.0
39303	Бусад биет бус хөрөнгө	41,060,000.0	41,060,000.0

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,676,556,835.7	1,844,510,319.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,676,556,835.7	1,844,510,319.1
51	Засгийн газрын хувь оролцоо	1,676,556,835.7	1,844,510,319.1
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	578,921,887.4	578,921,887.4
51101	Өмч: - төрийн	578,921,887.4	578,921,887.4
512	Хуримтлагдсан үр дүн	778,057,932.3	946,011,415.6
51210	Өмнөх үеийн үр дүн	778,057,932.3	778,057,932.3
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	167,953,483.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	319,577,016.1	319,577,016.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,676,556,835.7	1,844,510,319.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	836,561,649.5	915,196,368.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	317,992,139.0	298,514,581.0
120	Нийтлэг татварын бус орлого	317,992,139.0	298,514,581.0
120009	Бусад орлого	0.0	35,829,350.0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	312,992,139.0	247,657,506.0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	5,000,000.0	15,027,725.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	518,569,510.5	616,681,787.3
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.0	58,131,052.0
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	0.0	58,131,052.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	111,015,210.5	29,112,931.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	500,000.0	0.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	68,349,105.5	29,112,931.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	42,166,105.0	0.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	407,554,300.0	529,437,804.3
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	407,554,300.0	529,437,804.3
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	602,759,285.7	747,242,885.0

21	УРСГАЛ ЗАРДАЛ	583,668,635.7	713,009,951.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	466,587,065.7	712,009,951.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,689,995.2	363,758,254.3
210101	Үндсэн цалин	158,481,175.1	255,099,629.0
210102	Нэмэгдэл	33,883,751.4	98,964,039.6
210104	Урамшуулал	0.0	9,694,585.7
210105	Гэрээт ажлын хөлс	11,325,068.8	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,348,270.8	45,927,132.9
210201	Тэтгэврийн даатгал	17,364,686.0	31,380,269.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,111,616.9	3,652,500.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,629,520.0	2,939,640.9
210204	Ажилгүйдлийн даатгал	380,572.0	732,426.8
210205	Эрүүл мэндийн даатгал	3,861,875.9	7,222,296.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,934,195.0	74,757,659.1
210301	Гэрэл, цахилгаан	5,917,321.0	9,133,974.8
210302	Түлш, халаалт	49,016,874.0	65,138,684.3
210303	Цэвэр, бохир ус	0.0	485,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	27,848,956.0	21,466,493.6
210401	Бичиг хэрэг	3,475,200.0	2,308,500.0
210402	Тээвэр, шатахуун	22,844,686.0	16,635,143.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,529,070.0	1,553,800.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.0	969,050.0
2105	Нормативт зардал	1,218,600.0	815,800.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,218,600.0	815,800.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.0	8,111,700.0
210604	Урсгал засвар	1,500,000.0	8,111,700.0
2107	Томилолт, зочны зардал	4,090,000.0	3,850,000.0
210702	Дотоод албан томилолт	4,090,000.0	3,850,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	794,490.0	13,073,382.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.0	12,025,760.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.0	432,000.0

210803	Даатгалын үйлчилгээ	0.0	151,875.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	287,990.0	364,747.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	74,500.0	99,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	147,162,558.7	180,249,529.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,453,796.0	29,539,750.4
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	118,708,762.7	150,709,778.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	117,081,570.0	1,000,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,963,400.0	1,000,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,963,400.0	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	1,000,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	102,118,170.0	0.0
213304	Хөрөнгийн	102,118,170.0	0.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,090,650.0	34,232,934.0
2200	Дотоод эх үүсвэрээр	19,090,650.0	34,232,934.0
223001	Бусад хөрөнгө	19,090,650.0	34,232,934.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	233,802,363.8	167,953,483.4
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	233,802,363.8	167,953,483.4

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	518,569,510.5	652,511,137.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.0	35,829,350.0
120	Нийтлэг татварын бус орлого	0.0	35,829,350.0
120009	Бусад орлого	0.0	35,829,350.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	518,569,510.5	616,681,787.3
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.0	58,131,052.0
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	0.0	58,131,052.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	111,015,210.5	29,112,931.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	111,015,210.5	29,112,931.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	407,554,300.0	529,437,804.3

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	407,554,300.0	529,437,804.3
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	838,016,465.5	542,653,457.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	838,016,465.5	542,653,457.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	770,740,378.0	541,653,457.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,689,995.2	362,974,054.3
210101	Үндсэн цалин	158,481,175.1	254,315,429.0
210102	Нэмэгдэл	33,883,751.4	98,964,039.6
210104	Урамшуулал	11,325,068.8	9,694,585.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,348,270.8	45,927,132.9
210201	Тэтгэврийн даатгал	17,456,716.8	31,380,269.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,036,899.9	3,652,500.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,629,520.0	2,939,640.9
210204	Ажилгүйдлийн даатгал	379,274.3	732,426.8
210205	Эрүүл мэндийн даатгал	3,845,859.7	7,222,296.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	497,334,245.0	74,237,659.1
210301	Гэрэл, цахилгаан	5,884,321.0	6,276,600.0
210302	Түлш, халаалт	491,165,924.0	67,476,059.1
210303	Цэвэр, бохир ус	284,000.0	485,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	14,981,610.0	16,706,080.0
210401	Бичиг хэрэг	2,471,000.0	1,999,400.0
210402	Тээвэр, шатахуун	10,981,540.0	11,375,480.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,529,070.0	1,527,900.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.0	1,803,300.0
2105	Нормативт зардал	0.0	999,500.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.0	999,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.0	7,147,700.0
210604	Урсгал засвар	1,500,000.0	7,147,700.0
2107	Томилолт, зочны зардал	4,090,000.0	3,850,000.0
210702	Дотоод албан томилолт	4,090,000.0	3,850,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	794,490.0	3,145,872.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.0	2,098,250.0

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.0	432,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	0.0	151,875.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	287,990.0	364,747.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	74,500.0	99,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,001,767.0	26,665,459.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,001,767.0	26,665,459.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,276,087.5	1,000,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,963,400.0	1,000,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,963,400.0	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.0	1,000,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,312,687.5	0.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,312,687.5	0.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-319,446,955.0	109,857,680.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.0	109,857,680.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	109,857,680.0
2200	Дотоод эх үүсвэрээр	0.0	109,857,680.0
222001	Тоног төхөөрөмж	0.0	760,000.0
223001	Бусад хөрөнгө	0.0	55,962,574.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.0	53,135,106.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.0	-109,857,680.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-319,446,955.0	0.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	578,921,887.4	320,704,650.6	379,745,015.3	1,279,371,553.2
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,127,634.6	1,127,634.6
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	578,921,887.4	320,704,650.6	380,872,649.8	1,280,499,187.8
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	1,127,634.6	-	1,127,634.6

C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	302,698,496.3	302,698,496.3
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	578,921,887.4	321,832,285.2	683,571,146.1	1,584,325,318.6
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	578,921,887.4	321,832,285.2	683,571,146.1	1,584,325,318.6
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	578,921,887.4	321,832,285.2	683,571,146.1	1,584,325,318.6
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	167,953,483.4	167,953,483.4
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	578,921,887.4	321,832,285.2	851,524,629.5	1,752,278,802.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	579,902,900.0	564,637,703.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	529,866,900.0	514,895,623.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	528,866,900.0	513,895,623.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	353,671,800.0	348,135,951.3
210101	Үндсэн цалин	288,287,000.0	253,471,112.0
210102	Нэмэгдэл	65,384,800.0	84,842,672.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	127,580.8
210104	Урамшуулал	0.0	9,694,585.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,208,900.0	43,886,220.9
210201	Тэтгэврийн даатгал	30,062,100.0	29,929,421.1
210202	Тэтгэмжийн даатгал	3,536,700.0	3,521,120.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,829,300.0	2,689,255.3
210204	Ажилгүйдлийн даатгал	707,300.0	704,184.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,073,500.0	7,042,240.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,361,100.0	73,893,350.9
210301	Гэрэл, цахилгаан	6,276,600.0	5,932,291.8
210302	Түлш, халаалт	67,584,500.0	67,476,059.1
210303	Цэвэр, бохир ус	500,000.0	485,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	16,592,400.0	15,052,388.3

210401	Бичиг хэрэг	2,000,000.0	1,999,400.0
210402	Тээвэр, шатахуун	9,386,400.0	9,377,480.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,706,000.0	1,872,208.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.0	1,803,300.0
2105	Нормативт зардал	1,000,000.0	999,500.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.0	999,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,147,700.0	7,147,700.0
210604	Урсгал засвар	7,147,700.0	7,147,700.0
2107	Томилолт, зочны зардал	4,759,200.0	3,850,000.0
210702	Дотоод албан томилолт	4,759,200.0	3,850,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,827,000.0	4,854,472.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,500,000.0	3,806,850.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.0	432,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	230,000.0	152,181.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	565,000.0	364,441.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.0	99,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,298,800.0	16,076,040.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,298,800.0	16,076,040.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.0	1,000,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.0	1,000,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.0	1,000,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,036,000.0	49,742,080.0
2200	Дотоод эх үүсвэрээр	50,036,000.0	49,742,080.0
222001	Тоног төхөөрөмж	15,000,000.0	14,997,200.0
223001	Бусад хөрөнгө	35,036,000.0	34,744,880.0
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	579,902,900.0	564,637,703.2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	579,902,900.0	564,637,703.2
132001	Орон нутгийн төсвөөс	579,902,900.0	564,637,703.2
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	2.0
610001	Төсвийн байгууллага	1.0	2.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23.0	23.0
620001	Удирдах ажилтан	6.0	6.0
620002	Гүйцэтгэх ажилтан	9.0	9.0
620003	Үйлчлэх ажилтан	3.0	3.0
620004	Гэрээт ажилтан	5.0	5.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23.0	23.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.0	9.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.0	9.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5.0	5.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	70,363,000.00	87,873,434.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	70,363,000.00	31,757,834.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	31,757,834.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	14,965,683.85
210101	Үндсэн цалин	-	844,317.00
210102	Нэмэгдэл	-	14,121,366.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	1,913,331.24
210201	Тэтгэврийн даатгал	-	1,491,706.91
210202	Тэтгэмжийн даатгал	-	90,520.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	122,804.74
210204	Ажилгүйдлийн даатгал	-	28,242.73
210205	Эрүүл мэндийн даатгал	-	180,055.99
2104	Хангамж, бараа материалын зардал		1,998,000.00
210402	Тээвэр, шатахуун	947,700.00	1,998,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	41,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	41,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,706,600.00	12,839,419.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,706,600.00	12,839,419.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,708,700.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,340,100.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,368,600.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	56,115,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	56,115,600.00
223001	Бусад хөрөнгө	-	56,115,600.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	70,363,040.00	29,112,931.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,363,040.00	29,112,931.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,796,400.00	-

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,566,540.00	29,112,931.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,000,100.00	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газар нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагааныхаа чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах,
- Нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох
- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 15 зорилт, хэрэгжүүлэх 60 арга хэмжээтэй баталснаас нийт 98,3 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газарт дотоод аудитын нэгж байхгүй ба Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

Тус байгууллагад тайлант онд Төв аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 2022 оны 5 дүгээр сард 2020 болон 2021 оны санхүүгийн тайлангийн баримтад хяналт шалгалт хийсэн байна.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 167,953.5 мянган төгрөгөөр буюу 10 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	620.0	620.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	31,529.3	38,404.9	6,875.7
Үндсэн хөрөнгө	1,644,202.6	1,794,285.4	150,082.8
Нийт хөрөнгө	1,676,556.8	1,844,510.3	167,953.5
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,676,556.8	1,844,510.3	167,953.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,676,556.8	1,844,510.3	167,953.5

Дээрх хүснэгтээс харахад: Авлага дансны үлдэгдэл 620.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албаас Баянчандмань сумын өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэлт, түүний зарцуулалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 620.0 төгрөгийг авлага үүсгэх зөвлөмж өгсөн байна.

Бараа материал дансны хувьд тусгай зориулалтын материал 14,996.0 мянган төгрөг, аж ахуйн материал 1,043,200.0 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 500,000.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, бичиг хэргийн материал 320,000.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 9,920,000.0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд барилга байгууламж, орон сууц 63,993.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 14,926.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 21,242.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд хөрөнгө хасагдаагүй байна.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 12,250.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 14,926.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 21,242.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 2,967.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 1,750.0 мянган төгрөгийн программ хангамж худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 51,743.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 195,914.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,844,510.0 мянган төгрөг болж 167,954.0 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 402,204.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 177,698.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2023 оны урсгал зардлын төсвийг 579,902.9 мянган төгрөгөөр баталсан байна.

2023 онд батлагдсан төсөвт өөрчлөлт орж 579,902.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь 2023 онд алба хаагчдын цалин шат дараатайгаар нэмэгдсэнээс шалтгаалан орон нутгийн төсвийн санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 579,902.9 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Урьд оны үлдэгдлээс санхүүжсэн дүн 35,036.0 мянган төгрөг, Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 563,637.8 мянган төгрөг буюу 97,4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 13,093.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106/80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	451,645.40	438,551.53	13,093.87	97%
2	70106/ 80106 Баг хорооны ҮА зардал	58,422.7	57,464.8	957.9	98%
3	70106/80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ				
4	70106/80918 Бусад	50,036.00	49,742.08	293.92	99%
5	70106/ 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.00	4,999.79	0.21	99%
6	70106/82801 Улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	0	100%

7	71411/81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	6,298.80	6,076.25	222.55	96.5%
8	71411/82212 Хур хог хаягдал, орчныг бохирдол	2,500.00	1,803.30	696.70	72%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн захиргааны албан хаагчийн орон нутгийн нэмэгдэл цалин 29,112.9 мянган төгрөг, орон нутгийн нэгдсэн сангаас 58,131.1 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 35,829.4 мянган төгрөг нийт 123,073.4 мянган төгрөгийн орлого орсон байна.

Төрийн захиргааны албан хаагчийн орон нутгийн нэмэгдэл цалин 16,879.0 мянган төгрөг, ажлын байрны түрээсэнд 210.8 мянган төгрөг, тоглоомын талбайн санхүүжилтэд 56,115.6 мянган төгрөг, сумын өвс нөөц бэлтгэх тэжээлийн үнэ 5,123.2 мянган төгрөг, хагас жилийн мал тооллогын урамшуулалд 671.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 9,043.0 мянган төгрөгийн зардлыг шилжүүлж 35,199.9 мянган төгрөг татан төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106/ орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01-2023.12.31	Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах	92%	606,140.10	556,758.15
2	71411/Хүрээлэн буй орчны бодлого удирдлага	2023.01.01-2023.12.31	хэвийн үйл ажиллагааг хангах	90%	8,798.80	7,879.55

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянцогт сумын Засаг даргын Тамгын газар нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Баянцогт сумын Засаг даргын захирамжаар 569,687.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Шатахуун худалдан авах ажиллагааг тендер шалгаруулалтын онцгой журмаар зохион байгуулсан ба гүйцэтгэгчээр НИК ХК шалгарч гэрээ байгуулах эрх олгон барааг худалдан авч ажилласан.

Тайлант онд түлш халаалтын зардлыг Хив Повер ресурс ХХК, гэрэл цахилгааны зардлыг УБЦТС ХК, цэвэр бохир усны зардлыг Агтны манлай ХХК-тай шууд гэрээ байгуулан нийт 74,997.7 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авсан байна.

Мега Электроникс ХХК-аас 2 ширхэг зөөврийн компьютер, Си Ти ЭС ХХК-аас НББ-ийн цахим программ, Б.Ариунтуяагаас 1,020 ширхэг мод, Квант сервис ХХК-аас 2 ширхэг принтер, Финлогин ХХК-аас 1 ширхэг зөөврийн компьютер, Бест Электроникс ХХК-аас 1 ширхэг зөөврийн компьютер нийт 18,925.7 мянган төгрөгийн хөрөнгийг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Ерөнхий гэрээгээр цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Адъяасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02/29 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны үр дүнгийн тайлангийн орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 836,561.6 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 12,548.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9,411.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газар нь байгууллагад бүртгэлтэй 8089ТӨҮ, 8570ТӨА улсын дугаарыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасны дагуу цэнхэр дэвсгэрээр сольсон байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газарт авч хэрэгжүүлсэн өөр арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 169 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож, 166 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12 зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг мэдээлээгүй байсан ба аудитын явцад нөхөн байршуулсан.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж, 1 албан шаардлага өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	23,358.2	1	23,358.2	100%
Зөвлөмж	3	3,020.2	3	3,020.2	100%
Нийт дүн	4	26,378.4	4	26,378.4	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар нийт 7,652.4 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 7,652.4 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

1. Баянцогт сумын ЗДТГ-ын 2023 онд өглөгийн тайланд Хит Поверс ХХК-д төлөх 7,652.4 мянган төгрөгийг тусган тайлагнасан байна. Энэ нь 2023 оны халаалтын гэрээнд тусгаагүй илүү дүнгээр түлш халаалтын өглөг үүсгэн 7,652.4 мянган төгрөгөөр илүү зардал бичиж өр үүсгэсэн тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 137,229.3 мянган төгрөгийн 12 гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлээгүй байна. Энэ шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрээр долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл цалин олгосон

Илрүүлэлт: Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн “Төрийн албан хаагчдын ангилал зэрэглэл, цалин хөлсийг шинэчлэн тогтоож, орон нутгийн нэмэгдэл олгох тухай” Б/02 тоот захирамжийг үндэслэн сумын Улс төрийн 6 албан хаагчид орон нутгийн нэмэгдэл 9,243.4 мянган төгрөг олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17-д “Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

Илрүүлэлт: Баянцогт сумын ЗДТГ-ын биет бус хөрөнгийн бүртгэлд 16 газар, ГХБХБГ-аас ирүүлсэн газрын бүртгэлд 21 газар бүртгэлтэй байгаа бөгөөд бүртгэгдсэн газрын тоо болон үнэлгээний дүн тус тус зөрүүтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Газрыг Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн /цаашид "иргэн" гэх/, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуульд заасны дагуу эзэмшиж ашиглана”, 23 дугаар зүйлийн 23.3.9 “Аймаг нийслэлийн газрын алба нь газар эзэмших, ашиглах эрхийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28.1-д заасан журмын дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх эрхтэй”, 23 дугаар зүйлийн 23.4.3 “Сумын газрын даамал, дүүргийн газрын алба нь эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын хэмжээ заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, координатжуулах, тэдгээрийн кадастрын зургийг үйлдэж, газрын улсын бүртгэлд бүртгэх эрхтэй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай тооцоо нийлэх, зөрчлийг арилгах зөвлөмж өгөв.

2. *Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

Илрүүлэлт: Баянцогт сумын ЗДТГ-ын авто тээврийн хэрэгсэлд бүртгэлтэй 2022УНУ, улсын дугаарт цэнхэр дэвсгэртэй дугаар аваагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэх зөвлөмж өгөх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлагн алтай холбоотой алдаа	1	7,652.4			1	7,652.4	1	7,652.4				
Шилэн данс	1	137,229.3	1	137,229.3			1	137,229.3				
Дүн	2	144,881.70	1	137,229.3	1	7,652.4	2	144,881.70				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Улс төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл цалин олгосон.	1	9,243.5	1	9,243.5	-	-	-	-	-	-	-	-
Дүн	1	9,243.5	1	9,243.5	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Газрын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Баянцогт сумын ЗДТГ-ын биет бус хөрөнгийн бүртгэлд 16 газар, ГХБХБГ-аас ирүүлсэн газрын бүртгэлд 21 газар бүртгэлтэй байгаа бөгөөд бүртгэгдсэн газрын тоо болон үнэлгээний дүн тус тус зөрүүтэй байна.	1	-						1	-
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Баянцогт сумын ЗДТГ-ын авто тээврийн хэрэгсэлд бүртгэлтэй 2022УНУ, улсын дугаарт цэнхэр дэвсгэртэй дугаар аваагүй байна.	1	-						1	-
Дүн	2	-						2	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn